



**БЭЛЧЭЭРИЙН МЕНЕЖМЕНТ ТӨСЛИЙН НЭГЖ ОНӨТҮГ
ДАРГЫН ТУШААЛ**

2021 оны 11 сарын 17 өдөр

Дугаар 4/12

Улаанбаатар хот

**Байгууллагын жилийн эцсийн тооллогын
ажлыг зохион байгуулах тухай**

Монгол улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дах заалт, Монгол Улсын төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.2 дахь хэсэг, 72 дугаар зүйлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Байгууллагын эд хөрөнгийн 2021 оны жилийн эцсийн өмч хөрөнгийн үзлэг тооллогыг удирдан зохион байгуулж явуулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн

ахлагч:

З.Очирбат

Төслийн менежер

Гишүүд:

А.Гэрэлтуяа

Хүний нөөцийн менежер

М.Бат-Эрдэнэ

Механик

Нарийн бичиг:

Б.Баярцэцэг

Агрономч

2. Байгууллагын эд хөрөнгийн тооллогыг 2021 оны 12 дугаар сарын 14-ны өдрөөс 12 дугаар сарын 18-ны өдрийг хүртэлх хугацаанд багтааж чанартай зохион байгуулж дуусгахыг тооллогын комисст үүрэг болгосугай.

3. Тооллогыг удирдан зохион байгуулж, хяналт тавих, үр дүнг хэлэлцэн, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, санхүүгийн тайланд бүртгэлтэй дүн мэдээг 2021 оны 12 дугаар сарын 25-ны дотор танилцуулахыг тооллогын комисст даалгасугай.

ДАРГА



Н.УУГАНБАЯР